



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль

Хөтөлбөрийн нэр: Программ хангамж

Индекс: D061302

Шинжээч: Д.Оргил

Он сар өдөр: 2020 оны 05 сарын 18 өдөр

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль International University of Ulaanbaatar
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Программ хангамж Software engineer
Индекс	D061302
Шинжээч	Д.Оргил, ХААИС-ийн Инженер, технологийн сургуулийн ахлах багш
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Оюунчимэг
Төлөвлөлт	<ul style="list-style-type: none">- 5/14 Шинжээч урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх- 5/18 Сургууль дээр очиж, илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийх- 5/25 Шинжээчийн тайланг боловсруулж, мэргэжилтэнд хүлээлгэн өгөх- 5/29 Сургуулийн өөрийн үнэлгээний багаас шинжээчийн тайланд санал авах- 6/2 Шинжээчийн тайланг эцэслэн, мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд үнэлгээ дүгнэлтийг танилцуулах

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрийн нэр, индекс: D061302 Программ хангам /Software engineer/

Хөтөлбөрийн тодорхойлолт: Үндэсний болон олон улсын дээд боловсролын стандарт, инженерийн мэргэжилтний ерөнхий шаардлага, ажил олгогчдын шалгуур шаардлагыг хангасан, программ хангамжаар мэргэшсэн, тасралтгүй хөгжих чадвартай, өндөр ёс зүйтэй программ хангамжийн чадварлаг мэргэжилтэн бэлтгэнэ.

Хөтөлбөрийн харьяалал: Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн Компьютер Мэдээллийн Технологийн тэнхим

Хөтөлбөрийн эрхзүйн зохицуулалт: 2014 оны шинэчилсэн "Программ хангамж" хөтөлбөрийг хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэж, БСШУС-ын сайдын 2014 оны 04 сарын 28 өдрийн А/174 тоот тушаалаар баталсан "Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-ын дагуу боловсруулж, ОУУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2016 оны 05 сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, сургуулийн ерөнхий захирлын 2016 оны 05 сарын 06-ны өдрийн 01 тоот тушаалаар баталсан байна.

Хөтөлбөрийн түүх: Компьютер Мэдээллийн Технологийн тэнхим 1997 онд байгуулагдаж “Компьютерын программ хангамж”-ийн мэргэжлээр бакалаврын зэргийн сургалтыг явуулж эхэлсэн. “Программ хангамж” мэргэжлээр сургалт явуулж 15 удаагийн 538 мэргэжилтэн бэлтгэсэн. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол улсын холбогдох хууль тогтоомж, мэргэжлийн стандарт, олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмжүүдийн дагуу сургалтын хөтөлбөрөө тогтмол шинэчлэн боловсруулж хөтөлбөрийг хэрэгжүүлэн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангасан программ хангамжийн мэргэжилтэн бэлтгэх талаар зохих туршлагыг хуримтлуулан ажиллаж байна. 2015-2016 оны хичээлийн жилээс өөрийн үнэлгээний тайланг бичиж, ОУУБИС-ийн Хөтөлбөрийн Ерөнхий хороо болон Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний багийг байгуулан дараачийн шатны үнэлгээг хийлгэхээр ойрын зорилтыг тавьсан байна. 2019 онд хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлж, ДБМИК-оос нөхцөлтэйгөөр 1 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн ба шинжээчийн багийн болон комиссын зөвлөмж, шаардлагын дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлжээ.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

-Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/

-Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийгэм эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, программ хангамжийн мэргэжлээр төгсөгчдийн ажлын байрны судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг Монгол улсын хөдөлмөрийн яамнаас гаргасан “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2015”, Бизнэтворк сайтын 2018 оны 11 сард тавигдсан зар, НҮБ-аас зохион байгуулсан “Мэдээлэлжсэн нийгмийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалт”-ын баримт бичиг, Монголын Программ хангамж үйлдвэрлэгчдийн холбооны 2-р чуулганы 2015 оны материал, болон Засгийн газрын 2017 оны 47-р тогтоол “төрөөс мэдээлэл харилцаа холбооны талаар баримтлах бодлого 2017-2025” үндэслэн дүн шинжилгээ хийжээ.
- Гадаадын (Mississippi State University of Science in Software Engineering) болон дотоодын (МУИС болон ШУТИС-ийн Программ хангамж) ижил төстэй хөтөлбөртэй харьцуулсан байна.
- Ерөнхий эрдмийн 36 кр (28кр заавал, 8кр сонгох) хичээл судлахаас сургуулийн онцлог байдлаас оюутан бүр солонгос хэлний хичээлийг судлах боломжтой, мөн эдгээр хичээлүүд нь хувь хүний төлөвшил, хандлагад түлхүү нөлөөлөхөд чиглэсэн.

Анхаарах асуудал:

- “Software Engineering 2014 Curriculum Guidelines for Undergraduate Degree” зөвлөмжийн аль knowledge area болон knowledge unit-ийг тухайн хөтөлбөрөөр олгож байгаа болон олгохгүй үлдэж байгаа агуулгыг гаргах, үүн дээр дэлгэрэнгүй судалгаа шинжилгээ хийх

Зөвлөмж:

- Салбарын хурдтай хөгжил, нийгмийн шаардлагын улмаас төгсөгчдөд тавигдах шаардлага бас хувьсан өөрчлөгдөж байна. Эдгээр чиг хандлагад

тохируулан хөтөлбөрийн агуулгыг үнэлж шинэчлэн сайжруулах ажлыг тогтмолжуулж хэвшүүлэх хэрэгтэй.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тухайн программ хангамжийн мэргэжлийн хөтөлбөрийн зорилго, зорилт нь Мэдээлэл, холбоо технологийн тэнхимийн зорилго зорилт, ОУУБИС-ийн эрхэм зорилготой нийцэж байгааг тайланд тодорхой тусгасан.
- Хөтөлбөрт оролцогч талуудын санал, зөвлөмжийг тусгах загвар гаргасан байна.
- Багш нарыгаа CDIO хөтөлбөрийн сургалтад хамааруулж, хөтөлбөр боловсруулах арга зүйд сургаж, 2018-2019 оны хичээлийн жилээс хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж байгаа нь сайн талтай.
- Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах загварыг 2017 онд боловсруулж, хөтөлбөрийн ерөнхий хорооны 2017 оны 10 сарын 04 өдрийн хурлаар баталж, 2018-2019 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Тайланд хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг оруулах

Зөвлөмж:

- Сургууль, тэнхимийн түвшний хөтөлбөрийн хорооны идэвхтэй үйл ажиллагаа, сонирхогч талуудын хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөрийн үзэл баримтлал улам сайжирч, төгсөгчийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, мэргэжлийн чиг хандлага нь салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцэж байгаа байдалд илүү бодитой судалгаа хийж, хөтөлбөрийн өөрчлөлтөд тусгаж ажилладаг байх шаардлага байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан хөтөлбөр,
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Тухайн хөтөлбөр нь үр дүнд суурилсан боловсролын зарчимд тулгуурлан, CDIO стандарт, арга зүйн дагуу сайжруулагдан, шинэчлэгдсэн байгаа нь сайн талтай.
- Сургалтандаа CDIO-н сургалтын арга зүй, заах хэлбэр, үнэлгээний аргуудыг оруулж өгсөн байна.
- Тайланд 2007, 2011, 2013, 2014, 2016, 2018 оны хөтөлбөрийн шинэчлэлийн харьцуулсан судалгаа хийсэн.
- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг тодорхой хэмжээнд судалж хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгээ өөрийн сургуулийн эрхэм зорилго зорилттой уялдуулан боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хичээлүүдийн суралцахуйн үр дүн нь Блүүмийн таксономын аль түвшинд байгааг дүгнэх
- Багшийн тоог нэмэгдүүлэх (нэг багшийн зааж буй хичээлийн тоо 5-8 байна.)

Зөвлөмж:

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг нарийвчлан тодорхойлж хөтөлбөрийн өөрчлөлтөд тусгаж ажилладаг байх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан]

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- ОУУБИС-ийн “Программ хангамж” /061302/ сургалтын төлөвлөгөө 2019
- ОУУБИС-ийн Компьютер, мэдээллийн технологийн тэнхимийн хөтөлбөрийн дэд хорооны хурлын протокол
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- “Хичээл сонголтын журам “ 2015 он
- Сургалтын төлөвлөгөө 2019 он
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

Шинжээчийн баг, ДБМИКомиссийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Оюутны сонгон судлах мэргэжлийн хичээлүүдийн тоог нэмэгдүүлэх: Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж оюутны сонгон судлах мэргэжлийн хичээлүүдийн тоог 5-аар нэмэгдүүлсэн.
- Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж оюутан төгсөлтийн ажил хийх бололцоог нэмэгдүүлэх: “ОУУБИС-ийн оюутныг төгсгөх журам”-д төгсөлтийн ажил бичих голч оноо 3.5 гэж заасан байсныг 3.0 болгосон. Ингэснээр 2019-2020 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 40% нь төгсөлтийн ажил бичсэн.
- ОУУБИС-ийн хэмжээнд нэгдсэн сургалт удирдах системтэй болох: “College Management System”-ыг ашиглан оюутнууд <http://info.ubu.mn> сайтаар хичээл сонголт хийдэг. Харин багш нар <http://Prof.ubu.mn/> хаягаар орж сургалтын үйл ажиллагаагаа явуулдаг.
- Хичээл хоорондын залгамж холбоо, хичээлийн үр дүнгийн уялдааг нарийвчлан тодорхойлох: Хичээлүүдийн агуулгыг харьцуулж хичээл хоорондын агуулгын давхцалыг арилган залгамж холбоог шинэчилсэн.
- Суралцагчийн цагийн ачааллыг тооцсон судалгааг тайланд оруулах: Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгааг хийж өгсөн. Улирал бүр 18 кредитийн ачаалалтайгаар 8 улирал (4 жил) сурвал нийтдээ $18 \times 8 = 144$ кредитийн хичээлийг судлах боломж бүрдэнэ. Энэ нь өөрийн мэргэжлийн хичээлүүдээс гадна 20 орчим кредитийн хичээлийг сонирхлын дагуу нэмж судлах боломжтой.

- Мэргэжлийн хичээл заадаг багш сонгох боломж хомс: Мэргэжлийн хичээлүүдийн хувьд багшийг сонгох өргөн сонголт байдаггүй. Энэ нь тухайн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын тоотой холбоотой байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хичээл заадаг багш сонгох боломж хомс

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тухайн хөтөлбөрийн хичээлүүдэд CDIO стандартын 7-8 сургалтын аргыг ашигласан байна. Мөн түүнчлэн хичээл, арга зүйн хоорондын хамаарлын матриц гаргасан.
- Сургалтын албаны программаар улирал бүрийн эцэст тухайн улирлын хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээний талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг.
- Энэ судалгааны үр дүнгээр тэргүүлсэн багшийг урамшуулж, муу үнэлгээ авсан багшид зөвлөмж өгч, арга зүйг сайжруулах тал дээр ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хичээл хоорондын залгамж холбооны хяналт, сургалтын үйл ажиллагааг удирдах нэгдсэн системтэй болох

Зөвлөмж:

- Цаашид нэг хичээл зааж буй багш нар сургалтын арга зүйн судалгаа хийж, багаар хамтран ажиллах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/

-Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
-Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, сурлагын амжилт, чанар гэх мэт/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС-ийн захирлын 2011 оны 06 сарын 27-ны өдрийн 64 тоот тушаалаар батлагдсан “Оюутны мэдлэгийг үнэлэх журам”, БСШУ-ны сайдын 2003 оны 158 тушаалын “дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг чадварыг дүгнэхэд баримтлах журам”-ыг үндэслэн хичээл бүрээр оюутны мэдлэг чадварыг улирал бүрийн төгсгөлд үнэлдэг.
- Төгсөх оюутны мэдлэг чадварыг хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн агуулгаар улсын шалгалт авах буюу дипломын төсөл хийлгэх (6 улирлын голч 3.4 дээш) замаар үнэлдэг.
- Хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд хэрэглэгдэх үнэлгээний аргуудыг матрицаар харуулсан.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа (2014-2017)-аас суралцагчийн ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдлыг тодорхойлж гаргасан.
- 2014-2018 оны суралцагчдын сурлагын амжилт, чанар, ахицын талаарх статистик мэдээг жил, улирал бүрээр гаргасан.

Зөвлөмж:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргуудын судалгаа хийх
- Мэргэжлийн хичээлийн шалгалтын нэгдсэн сан үүсгэх

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан]

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн байр сургалтын үйл ажиллагаа хийх шаардлага бүрэн хангасан. Тухайлбал: Шинээр 6 давхар 6146 м2 хэмжээ бүхий сургалтын 2-р байрыг ашиглалтад оруулсан.
- Мэргэжлийн хичээлийн лаборатори, тоног төхөөрөмж сайн. Тухайлбал: 2018 онд 120 ширхэг (Core 2 Dou, 2G memory) компьютероор лаборатори сайжруулсан.
- Номын сангийн суудлын хүрэлцээ хангалттай сайн, номын санчийн үйл ажиллагаа идэвхтэй байсан.
- Хичээлийн байрны хангалттай тодорхой цэгт утасгүй интернэтийн хангамж хангалттай сайн.

Шинжээчийн багийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Өндөр үзүүлэлт бүхий компьютер шаардагдах программтай ажиллах (MS Visual, JAVA, PHP framework-ууд зэрэг хөгжүүлэлтийн хэрэгслүүдийн шинэ хувилбарууд, гэх мэт) компьютерын лаборатори дутагдалтай: Санах ойн хэмжээг 4G, микропроцессор нь "i5" төрлийн 30 ш компьютертой лаборатори (B309) байгуулсан.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Лабораторийн хэрэглээ сайн, хэрэглэж байгаа программ хангамж шаардлага хангасан.
- Хичээлийн хэвлэмэл үзүүлэн, заавар, удирдамж, зөвлөмж, тараах материал, хэрэглэгдэхүүнийг цахим хэлбэрээр ашигладаг, багш нар өөрийн хүчээр монгол хэлэнд хөрвүүлэх, бэлтгэх ажлыг байнга хийдэг.

Анхаарах асуудал:

- Сургалтын хэрэглээ болон үйл ажиллагааны хүрээнд ашиглаж байгаа программ хангамжуудыг албан ёсны лицензжүүлэх тал дээр анхаарах

Зөвлөмж:

- Программчлалын хичээлд хэрэглэдэг программууд, framework, хэрэгслүүдийн шинэ хувилбаруудыг ашиглах, лабораторийн компьютерт суулган бэлтгэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Багш, оюутан нарын хувьд сургалтын цахим системийг ашиглалт хангалттай сайн.
- Багш нар өөрийн хичээлээр блог хөтлөн оюутнуудад цахим хэлбэрээр түгээдэг.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн ном сурах бичгийн хүртээмжийг сайжруулах. Өөрөөр хэлбэл номын санд байгаа мэргэжлийн сурах бичгийн тоог нэмэгдүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан]

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө.
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС-ийн Захирлын 2014 оны 5-р сарын 30-ны өдрийн 58 дугаар тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн хороо байгуулах тухай”, 2015 оны 11-р сарын 19-ны өдрийн 232 дугаар тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн хорооны журам батлах тухай”, 2015 оны 11-р сарын 25-ны өдрийн тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” зэргийг хөтөлбөр боловсруулах ажилд мөрдөж ажилладаг.
- Хөтөлбөр болон бусад тулгамдсан асуудлаар ангийн дарга нартай захирал байнга уулздаг.
- Захирлын ажлын албаны дэргэд санал, гомдлын хайрцаг ажиллуулдаг.
- Оюутны алба дээр мөн санал гомдлын хайрцаг ажиллуулдаг.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС-ийн Захирлын 2015 оны 11-р сарын 17-ны өдрийн тушаалаар батлагдсан “ОУУБИС-ийн оюутан солилцооны журам” мөрдөн ажилладаг.
- Тус сургууль нь БНСУ, ОХУ, АНУ, БНХАУ зэрэг орнуудын 95 их дээд сургуультай харилцаа холбоотой ажилдаг, БНСУ-ийн их дээд сургуулиудтай оюутан солилцох ажил амжилттай хийдэг.
- 2015 онд БНСУ-ын HANNAN их сургуулийн Компьютерын шинжлэх ухааны сургууль, Холбоо Мэдээллийн тэнхимтэй 2+2 хөтөлбөрийн гэрээ байгуулсан, амжилттай хэрэгждэг.
- БНСУ –аас сургалтын орчин, анги танхим , тоног төхөөрөмж сайжруулах чиглэлээр хөрөнгө оруулалт их хийгддэг.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон Улсын Улаанбаатар их сургуулийн нэгдсэн төсвөөс буюу оюутны сургалтын төлбөр, бусад орлогоос санхүүждэг.
- Нэг оюутанд ноогдох дундаж зардал 2.3 сая төгрөг байдаг. Энэ дүн сүүлийн 2 жилд тогтмол байна.
- 2013-2018 онд программ хангамж хөтөлбөрөөр дотоодын болон гадаадын тэтгэлэг, дэмжлэгт хамрагдсан оюутны тоо тогтмол өссөн бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилд 22,36 сая төгрөг болж өссөн.
- Оюутны арга хэмжээнд зарцуулсан төсөв сүүлийн 5 жилд оюутны тоонд харьцуулснаар өссөн бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилд 8.1 сая төгрөг байсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн төсөв, санхүү бие даагаагүй.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг жилд нэг удаа хийдэг,
- Төгсөгчид, Ажил олгогчдын уулзалтыг жил бүр хийдэг, тэдний саналыг авч судалгаа хийдэг.
- Программ хангамжийн хөтөлбөрөө нийтэд таниулах зорилгоор жил бүр элсэлтийн төлөвлөгөө гарган ажилдаг.

Анхаарах асуудал:

- Маркетинг идэвхжүүлэлтийг сайжруулах, элсэлтийн тоог нэмэгдүүлэх тал дээр ажиллах шаардлагатай.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Веб сайтын ажиллагаа, мэдээллийн санд оруулсан, нийтэд түгээж буй мэдээлэл маш сайн.
- Сургууль, түүний салбар тэнхимүүд сургууль, мэргэжил сурталчлах ажлыг тухайн жилийн төлөвлөгөөндөө зайлшгүй тусган ажилдаг. Тухайлбал жил бүр 5, 6 –р сард ерөнхий боловсролын зарим сургуулиуд дээр энэ үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах, мэдээлэл боловсруулах чадамжийг дээшлүүлэх дал дээр анхаарах шаардлагатай.

Зөвлөмж:

- Доржготов багшийн санаачлан хэрэгжүүлж байгаа Сургалтын Удирдлагын Систем (edmodo - Learning Management System) -ийг мэдээлэл болон мэдлэг түгээх, тест, шалгалт авах, сургалт явуулахад нь багш, оюутнуудад туслах, холбох оновчтой хэрэгсэл юм. Энэхүү Сургалтын Удирдлагын Системийг албан ёсоор нь нийт багш, оюутнуудад ашиглуулж сургах.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан]

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журам
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүрийн элсэлтийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын “Их, дээд сургуульд оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам”-ын дагуу зохион байгуулдаг. Элсэлтийн ерөнхий шаардлагуудаас гадна хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх боломжтой.
- Программ хангамж мэргэжлээр элсэгчдийн тоо, дундаж оноо өссөн, бүртгүүлсэн ба элссэн оюутны тооны зөрүү буурсан эерэг үзүүлэлттэй гарчээ.
- Хичээлийн жил бүр шинэ элсэгчдийг хүлээн авах өдөрлөг зохион байгуулдаг. Оюутнуудыг гарын авлагаар бүрэн хангасан. Ингэхдээ үнэ төлбөргүйгээр оюутан бүрт тарааж өгдөг.
- ОУУБИС-ийн “Гадаад оюутан элсүүлэн суралцуулах журам”-ын дагуу гадаад оюутан элсүүлэн суралцуулдаг. Гадаад оюутны тоо жил ирэх тусам өссөн үзүүлэлттэй байна. Харин программ хангамж мэргэжлээр гадаад оюутан огт суралцаагүй.

Зөвлөмж:

- Программ хангамж мэргэжлээр гадаад оюутан элсүүлэх талаар бодлого боловсруулах

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зөвлөх багш оюутныг элсэн орсон эхний өдрөөс эхлэн ОУУБИС-ийн дүрэм, журмын дагуу заавар, зөвлөгөө өгч ажилдаг. Оюутны алба, сургалтын алба, зөвлөх багш нягт хамтарч ажилладаг.

- Оюутанд чиглэсэн үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг авдаг бөгөөд өөрсдийн үйл ажиллагааг сайжруулах, оюутанд үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, тоог нэмэгдүүлэх чиглэлээр тусган ажиллаж байна.
- Хувь хүний хөгжлийн сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Оюутанд олон төрлийн урамшуулал тэтгэлэг олгодог. Сайн дурын ажлыг үнэлдэг системтэй.
- Тэнхимийн дэргэд оюутан, багш нарын хамтарсан судалгааны багийг байгуулсан бөгөөд сургуулийн захиалгат программ хангамжуудыг хөгжүүлдэг. Тус баг оюутны эрдэм шинжилгээний хуралд удаа дараа амжилттай оролцсон байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл.
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудад хандан олон төрлийн дугуйлан секцийг тогтмол хичээллүүлдэг. Дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэхийн тулд багш нарыг бодитоор урамшуулдаг байна. Ингэхдээ дугуйлангийн үйл ажиллагааны тайланг харгалзан үзэж “В” цагийн үнэлгээг тооцдог.
- “Нийгмийн үйлчилгээний тэтгэлэг” оюутны сайн дурын ажлыг явуулж оюутнуудын нийгмийн идэвхийг нэмэгдүүлдэг. Оюутнуудын хийсэн ажлыг нь үнэлж сургалтын төлбөрөөс хөнгөлдөг байна.
- Оюутнуудыг цагийн ажлаар хангахын тулд нийслэлийн хөдөлмөрийн газартай хамтран өдөрлөг сургалтыг зохион байгуулдаг.
- Оюутнуудын дунд программчлалын дугуйлан тогтмол хичээллүүлдэг нь программчлалын улсын олимпиадад амжилттай оролцох үндэс нь болсон байна.
- Сургалтын тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо тогтмолжсон, мөнгөн дүн өссөн байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийг ажлын байраар хангах тал дээр анхааран ажиллах

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 4 жилийн байдлаар программ хангамж хөтөлбөрөөр нийтдээ 12 оюутан шилжин ирсэн, 92 оюутан гарсан байна.
- ОУУБИС оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулдаг өөрийн дүрэм журамтай бөгөөд сүүлийн жилүүдэд уг журмыг шинэчилсээр иржээ.

Анхаарах асуудал:

- Шилжин ирсэн болон гарсан оюутны талаарх судалгааг нарийн гаргаж, шилжиж буй шалтгааныг тодорхой болгож, багасгах асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах.

Зөвлөмж:

- Суралцагчийн эрх ашгийг дээдэлж буй талаарх мэдээллийг нээлттэй болгох

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

Төгсөлтийн баримт бичгийн загвар

-Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичиг нь БСШУЯ-ны “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” А/78 тушаал, ОУУБИС-ийн “Сургалтын журам”, “Оюутныг төгсгөх журам”-ын дагуу зохицуулагддаг.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан]

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш, суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийг сонгон шалгаруулж авах эрх зүйн тогтолцоо бүрдсэн. Стратеги зорилго 5-д дэлхийн жишиг их сургууль болох зорилгыг биелүүлэхийн тулд “Хүний нөөцийн ажлын бүтээмж”, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх тогтолцоог бүрдүүлж, залуу боловсон хүчнийг дэмжих үйл ажиллагааг явуулна гэж тусгасан. Энэ зорилгыг хэрэгжүүлэхээр үйл ажиллагаандаа холбогдох дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагын тогтолцоотой. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах ерөнхий болоод тусгай шаардлагуудыг ханган ажилладаг.
- Тодорхой зэрэглэлд ажиллаж байгаа багшийн ажилласан жил, ажил үүргийн гүйцэтгэлийн үр дүн, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг харгалзан цалингийн шатлалыг ахиулдаг. Мөн оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар эхний 3 байранд орсон багш нарыг мөнгөн шагналаар урамшуулдаг.

Шинжээчийн баг, ДБМИКомиссын шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Доктор зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх талаар тодорхой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай: ОУУБИС-ийн Компьютер мэдээллийн Технологийн тэнхимийн багш нарыг хөгжүүлэх хөтөлбөр 2015-2023”-д хамтын ажиллагаатай гадаадын их сургуулиудын болон дотоодын их сургуулиудын докторантурт багш нараа сургахаар төлөвлөсөн. 2019-2020 оны хичээлийн жилээс доктор зэрэгтэй багшийн эзлэх хувь 43% болж өссөн.

Зөвлөмж:

- Нэг багш олон мэргэжлийн хичээлийг зааж байгаа нь дутагдалтай.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт
- Төлөвлөгөө, тайлан

-Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургууль хичээлийн жилийн эхэнд жилийн ажлын төлөвлөгөө гаргадаг бөгөөд энэ төлөвлөгөөтэй уялдуулж тэнхим салбар нэгжүүд хичээлийн жилийн ажлын төлөвлөгөө гаргаж ажилладаг.
- “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулж батлуулан хэрэгжүүлж байна. Тэнхим “Программ хангамжийн тэнхимийн багш нарыг хөгжүүлэх хөтөлбөр”-г батлуулан хэрэгжүүлж байна.
- Багш нар гадаад оронд мэргэжил дээшлүүлэх холбоо харилцааны боломж бүрдсэн. Багшийн урт ба богино хугацаанд мэргэжил ур чадварыг нь дээшлүүлэх ажлын хүрээнд сургуулийн зүгээс хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулиудын докторантурт хөнгөлөлт, тэтгэлэгээр суралцуулах, дотоодын их сургуулиудын докторантурт суралцах үеийн ажлыг зохицуулж, тасралтгүй суралцах боломжоор хангаж ирсэн.

Шинжээчийн баг, ДБМИКомиссын шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Багшийн эрдэм шинжилгээ судалгааны ажлыг бодитойгоор дэмжих: 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн багш нарынхаа эрдэм шинжилгээ, судалгааны ажилд нь дэмжлэг үзүүлэх үүднээс танхимын сургалтаас бусад цагийг багш өөрийгөө хөгжүүлэх, судалгааны ажлаа хийхэд зориулж чөлөөлж өгсөн.
- Багш нарын сургалтын кредитийн хэмжээг үндсэн нормоос 1-ээр багасгаж, эрдэм шинжилгээний кредитийн хэмжээг 1-ээр нэмэгдүүлсэн.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентын тоон судалгаа
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо
- Зарцуулсан төсөв, тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Программ хангамж хөтөлбөрийн багш нар нь программ зохион бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг хийдэг бөгөөд программ хангамжийн бүтээлийн төрлөөр 2 зохиогчийн эрх авсан байна. Мөн 1 номоор зохиогчийн эрх авсан.

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дунд хугацааны 2020 оны төлөвлөгөө баталж стратеги зорилтуудыг дэвшүүлсэн байна.
- Тэнхимийн багш оюутны судалгааны баг нь гадны байгууллагын захиалгат, хамтарсан төслүүдэд гүйцэтгэгчээр ажиллаж ирсэн.
- Тус тэнхимийн багш нар нь эрдэм шинжилгээний ажлаа олон улсын хуралд илтгэх, гадаадын нэр хүнд бүхий сэтгүүлд хэвлүүлэх тал дээр нэлээн анхаарч ажиллаж байна. Дотоодод хэлэлцүүлсэн илтгэл, хэвлүүлсэн өгүүллийн тоо буурсан нь анхааруштай үзүүлэлт болж байгаа хэдий ч гадаадад хэлэлцүүлсэн илтгэл, хэвлүүлсэн өгүүллийн тоо өссөн.

Шинжээчийн баг, ДБМИКомиссын шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төсөв харьцангуй бага: Программ хангамж хөтөлбөрийн ЭШ-ний зардал 2017-2018 онд 3.72% байсан бол 2018-2019 онд 10.65% болгон өсгөсөн.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн жил бүрийн төгсгөлд багш өөрийн үнэлгээний тайлан, албан тушаалын зэрэглэлд харгалзах цагийн гүйцэтгэлийн тооцоог тэнхимтэй хийдэг.
- Багшийн үйл ажиллагааг тогтмол үнэлж, амжилтыг нь урамшуулж, алдаа дутагдал гарвал засах залруулах ажлыг тогтмол хийдэг.
- Хичээлийн жилийн улирал бүрийн эцэст оюутнуудаар багшийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч багш бүр, тэнхим бүрийг үнэлэн дүгнэж тэдний чадвар чансааг тогтоодог.
- Багш өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр багш тус бүр 3 жилийн ажлын төлөвлөгөө гаргаж, түүний биелэлтийг аттестатчлалын гол үзүүлэлт болгон ажиллаж байна.
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримтжуулалт сайн. Багшийн ажлыг үнэлэх үнэлгээний аргачлалтай.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан]

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем

-Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУУБИС-ийн хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт нь хөтөлбөрийн ерөнхий хороо болон дэд хороо (тэнхим)-гоор дамжин хийгддэг.
- Хөтөлбөрийн чанарыг сайжруулахад
 - Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
 - Төгсөгчдийг мөшгөх судалгаа
 - Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
 - Хөдөлмөрийн зах зээлийн тандалт судалгаа дээр үндэслэн өөрийн үнэлгээ дүгнэлт гаргаж сайжруулах зүйлсийг төлөвлөдөг.
- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангах зохион байгуулалтын үр дүнд БСШУСЯ-ны А/174 тушаалын хавсралтад заасан бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу 2014 он, 2016 онд мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулж, 2018-2019 оны хичээлийн жилд хөтөлбөрийг дахин сайжруулах, хэрэгжилтэд хяналт тавих ажил хийгдсэн.
- Ажил олгогчоос өгсөн мэдлэг ур чадварын үнэлгээнд мэргэжлийн хүрээнд эзэмшсэн онолын мэдлэг, багаар ажиллах чадвар, харилцааны ур чадвар дунджаас дээш гэсэн үнэлгээ өгсөн. (Хүснэгт 7.1)

ДБМИКомиссын шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж хөтөлбөрийн үр дүнд үнэлгээ хийх: 2019 - 2020 оны хичээлийн жилд сургалтын албаны харьяанд “Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын төв” байгуулан ажиллаж эхэлсэн. 2019 – 2020 оны хичээлийн жилийн 1-р улиралд КМТ-ийн тэнхимийн мэргэжлийн суурь 6, мэргэшүүлэх 9 хичээл дээр үнэлгээ хийж сэтгэл ханамж өндөр гэсэн үр дүн гарсан.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 1997 оноос 2018 оны хавар хүртэл нийт 576 оюутан төгссөн байна. Программм хангамжийн хөтөлбөрөөр элсэгчид дунджаар 42%-тай бакалаврын шатны сургалтаа бүрэн дүүргэжээ.
- 2014-2017 оны төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа авсан байна. Мэргэжлийн ажил эрхлэлтийн хувь 58%, нийт ажил эрхлэлтийн хувь 82% байна.
- Ажлын байраар хангагдах хүртлээ зарцуулсан хугацааны 210 төгсөгчдөөс авсан судалгаагаар 70.1% нь 6 сарын дотор ажилд орж чадсан.
- Магистрын хөтөлбөрт нийт 83 оюутан элсэн суралцсанаас энэ жилийн байдлаар 13 оюутан амжилттай төгссөн байна.
- Жил бүр төгсөгчидтэй уулзалт зохион байгуулдаг.

Шинжээчийн баг, ДБМИКомиссын шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажил:

- Мэргэжлээрээ ажил эрхлэх төгсөгчийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах: ОУУБИС-ийн дэргэд “Оюутныг ажилд зуучлах төв” ажилладаг. Төгсөгчдийг ажилд зуучилсан багш нарын В цагт кредит тооцох журам үйлчилдэг.
- Төгсөгчидтэй мэргэжлийн чиглэлээр түлхүү эргэх холбоо үүсгэх, ахисан түвшинд суралцуулах тал дээр анхаарах: Тус сургуулийг төгссөн төгсөгчдийн нэгдсэн холбоо ажилладаг. Тус холбооны зорилго нь төгсөгчидтэй эргэх холбоо үүсгэх, тэднийг ахисан түвшинд сургах, богино хугацааны сургалтад хамруулах, төгсөгчдөөс одоо суралцагчдад зөвлөгөө тусламж үзүүлэх, мэргэжлийн чиглэлээр хамтарсан хурал, семинар зохион байгуулахад оршдог.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр

-Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
-Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.
-Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн онцлог нь мэргэжлийн ур чадвараас гадна солонгос хэлний мэдлэгтэй
- Улсын бүртгэлийн ерөнхий газар хэрэгжсэн “Хуулийн этгээдийн бүртгэлийн систем”-ийг Солонгос программистууд болон ОУУБИС-ийн программ хангамжийн төгсөгчид хамтран гүйцэтгэсэн.
- Z24 Mongolia олон улсын тийз захиалгын компанийг төгсөгчид үүсгэн байгуулж амжилттай ажиллаж байгаа.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан]

ДУГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2	Сургалтын үйл ажиллагаа	+			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+			
6	Багшийн үйл ажиллагаа	+			
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	+			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	Салбарын хурдтай хөгжил, нийгмийн шаардлагын улмаас төгсөгчдөд тавигдах шаардлага бас хувьсан өөрчлөгдөж байна. Эдгээр чиг хандлагад тохируулан хөтөлбөрийн агуулгыг үнэлж шинэчлэн сайжруулах ажлыг тогтмолжуулж хэвшүүлэх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	Цаашид нэг хичээл зааж буй багш нар сургалтын арга зүйн судалгаа хийж, багаар хамтран ажиллах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	Хичээлд хэрэглэгдэж байгаа программуудыг бүрэн лицензжүүлэх
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Сургалтын Удирдлагын Систем (edmodo - Learning Management System) -ийг мэдээлэл болон мэдлэг түгээх, тест, шалгалт авах, сургалт явуулахад нь багш, оюутнуудад туслах
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	Программ хангамж мэргэжлээр гадаад оюутан элсүүлэх тал дээр бодлого боловсруулах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	Нэг багш олон мэргэжлийн хичээлийг зааж байгаа асуудлыг шийдэх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ОУУБИС-ийн “Программ хангамж” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн нэр, гарын үсэг...../Д.Оргил/

М. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

**ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ**

210644 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
Намынжүгийн гудамж, Утас: 462046 Факс: 976-11-462040
E-mail: info@iuu.edu.mn, iuu.edu.mn

2020.05.29 № 4/254
танай _____-ны № _____-т

Шинжээчийн тайлантай танилцсан тухай

Тус сургуулийн Компьютер мэдээллийн технологийн тэнхимийн
“Програм хангамж” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний
тайланд өгсөн шинжээчийн багийн тайлантай танилцлаа.

Бидний зүгээс шинжээчийн багийн өгсөн дүгнэлт, санал, зөвлөмжийн
дагуу өөрийн үнэлгээний тайлан, мэргэжлийн хөтөлбөрөө сайжруулж ажиллах
болно.

СУРГАЛТЫН АЛБАН ДАРГА



Б.ОЮУН-ЭРДЭНЭ